

Сэдэв: Олон улсын ачаа тээвэрлэлтийн бусад хэлбэрүүд




- Өмнөх хичээлүүдэд үзсэн агаарын, автозамын, төмөр замын, далайн тээвэрлэлтүүд дангаараа орчин үеийн олон улсын худалдаанд ашиглагдахаас гадна дээрх хэлбэрүүд холимог байдлаар хэрэглэгдэх нь элбэг тохиолддог. Ийм хэлбэрийн тээвэрлэлтийг олон улсын хэмжээнд олон төрөлт тээвэрлэлт (multi-model) буюу холимог тээвэрлэлт гэж нэрлэж байна.
- Олон төрөлт тээвэрлэлт нь тээврийн 2 ба түүнээс дээш төрөл хэлбэрүүдийг ашиглан алс хол зайд явагддаг тул тээвэрлэлтийн онцгой горимыг шаарддаг.

Дамжуулах хоолойн тээврийг нефть шатдаг хий г.м зүйлсийг тээвэрлэхэд ашиглаж байна. Тээвэрлэлтийг хамгийн хямд өртөг зардлаар үйлддэг дамжуулах хоолойн тээвэрлэлт сүүлийн жилүүдэд огцом өсөх хандлагатай байгаа юм.



- Цахилгаан эрчим хүчийг цахилгаан шугамаар дамжуулан худалдаалдаг. Мэдээллийн үйлчилгээг интернетийн сүлжээ харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан худалдаалж байна. Орчин үед электрон худалдаа нэлээд өргөн дэлгэр хэрэглэгдэх болсон.
- Электрон худалдааны гэрээ хэлцэл нь компьютерын сүлжээгээр дамжин хийгддэг боловч барааг нийлүүлэх үйл ажиллагаа нь тээвэрлэлтийн уламжлалт аргуудаар дамжин хийгдэж байгаа.



- Нефтийг дамжуулах хоолойгоор анх Америкт 1985 оноос тээвэрлэж эхэлсэн. Дамжуулах хоолойг ашиглан нефть, хийг тээвэрлэхээс гадна зарим нэг хатуу биетийг тухайлбал чулуун нүүрсийг дамжуулах хоолой олон улсад ашиглагдаж эхлээд байна. Түүнчлэн нефть, хийн орд газарт цооногуудын болон нефть хийн агуулахуудын холболтын аль эсвэл хуваарилалтын их хэмжээний шугам хоолой ашиглагддаг.
- Дамжуулах хоолойн тээвэрлэлт нь бусад төрлүүдээс хамгийн бага зардалтай.

Дутагдалтай тал нь:

- Дамжуулах хоолойг байгуулж дууссаны дараа чиглэлийг өөрчлөх боломжгүй.
- Их хэмжээний металл орно

1956 онд Америкт анх удаагаа тээвэрт “контейнер” – ийг ашигласнаар энэ нь нэг ёсны бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийг стандартчилах эхлэл болсон гэж үздэг. Өнөөдөр “контейнер” – ийг хамгийн үр дүнтэйгээр хэрэглэж байгаа тээврийн систем нь холимог тээвэрлэлт болоод байна.



Контэйнерийн тээврийн төрөл:

- Dry container - Энгийн бүтээгдэхүүн
- Reefer container - Хөлдөөх шаардлагатай бүтээгдэхүүн
- Solid bulk container - Үр тариа
- Open top container - Хүнд ачаа тээвэр
- Tank container - Химийн бодис, бүтээгдэхүүн
- Pen container - Амьд амьтан

Standard



Flatracks



High-Cube



Hard-Top



Open-Top



Platforms



Ventilated



Refrigerated



Bulk



Tank



Контэйнер тээвэрлэлтийн ашигтай тал:

- Эдийн засгийн хувьд: Хадгалалт, даатгал, тээврийн зардал бага
- Цаг хугацааны хувьд: Газраар, усаар тогтмол тээвэрлэх системийг бий болгосон
- Аюулгүй байдлын хувьд: Бат бөх металлээр хийгдсэн.

Контэйнерт ачих бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийн ангилал:

- Дээд зэргийн бараа: Өндөр үнэтэй бараа, овор багатай электрон бараа.
- Тохирсон бараа: Цахилгаан бараа, ууттай кофе, арьс, нэхий бүтээгдэхүүн.
- Хязгаартай бараа: Хүнд төмөр, шахмал мод ←=== ашиг багатай бараа
- Үл тохирсон бараа: Бараг боломжгүй бараа /том ачааны машин, багана, төмөр суварга г.м./

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

